



Гүйцэтгэлийн аудитын  
тайлан

***ЭМЯ-наас зөвлөмж болгосон 13 төрлийн амин дэм болон 14 төрлийн эрдэс бодисын 40 хувь нь хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын эмхэтгэлд ороогүй, 85 хувь нь хоолны технологийн картад тусгагдахгүй байна.***

2020 оны 12  
дугаар сар

**Аудитын сэдэв: "ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХООЛ,  
ХҮНСНИЙ ЗАРДЛЫН ЗАРЦУУЛАЛТ, ҮР АШИГ"**

## АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
<b>1.1 Хоолны зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт оновч муутай, бодитой судалгаанд үндэслээгүй байна.</b>	5
1.1.1 Эрүүл мэндийн байгууллагын хувьд хоолны зардалд үнийн тааз тогтоогоогүй, аймаг, сумдын хүн амын тооноос шалтгаалж ялгаатай төлөвлөсөн байна.	5
1.1.2 Хоолны зардлын төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хуваарилахгүй байна.	5
<b>1.2 Хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан боловч хувь хүнээс хямдруулсан үнээр худалдан авах боломжтой хүнсний бүтээгдэхүүнийг жижиглэнгийн үнээр авч байна.</b>	6
1.2.1 Мах, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад хүнсний материалын худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.	6
1.2.2 Аймгийн төвийн байгууллагууд үхэр, хонины махыг сумдын дундаж үнээс 630-1051 төгрөгөөр өндөр үнээр бэлтгэж байна.	6
<b>2.1 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд норм, нормативыг баримтлаагүй, хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын мэдээлэл тодорхой бус, ялгаатай хүснэгтүүдийг ашиглаж байна.</b>	7
2.1.1 Зарим ЭМТ-ийн нэг хүнд ногдох хоногийн хоолны зардал харилцан адилгүй байна.	7
2.1.2 Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгтэд 13 төрлийн амин дэм, 14 төрлийн эрдэс бодисыг бүрэн тусгаж, олон нийтэд зориулж цахимд байршуулах шаардлагатай байна.	7
<b>2.2 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг хангахгүй байна.</b>	9
2.2.1 Хоолны технологийн картын бүтэц, агуулга одоогийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.	9
2.2.2 Эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл шаардлага бүрэн хангагдаагүй байна.	9
2.2.3 Тусгай шилжүүлгийн зарим байгууллагын хувьд тогоочийн орон тоо хүрэлцээгүй, илүү цагийн хөлс олгоогүй байна.	9
ДҮГНЭЛТ:	11
ЗӨВЛӨМЖ:	11

### Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>	<b>Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл</b> Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын "Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/100 дугаар тушаалын дагуу "Төсвийн байгууллагуудын хоол, хүнсний зардлын зарцуулалт, үр ашиг"-д Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.
<b>Аудитын зорилт</b>	Төсвийн байгууллагуудын хоол, хүнсний зардлын зарцуулалт, үр ашигт аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.
<b>Аудитын хамарсан хүрээ</b>	Аудитад зарим сумдын сургууль, цэцэрлэг, ЭМТ холбогдох байгууллагын үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b>	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, төсвийн гүйцэтгэл, хоолны өдөрлөг, хоолны цэс технологийн карт, хүнсний материалын тайлан, хүүхдийн ирцийн бүртгэл, хэвтэн эмчлүүлэгчийн бүртгэл, бусад шаардлагатай баримт материал, хоол үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн дотоод хяналтын тайлан, статистик судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа</b>	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Нарантуяа удирдаж, аудитын менежер Г.Даваа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх нар гүйцэтгэв.

**БҮЛЭГ 1. ХООЛНЫ ЗАРДЛЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХУВААРИЛАЛТ ХАРИЛЦАН АДИЛГҮЙ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХУУЛИЙН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН Ч ХУВЬ ХҮНЭЭС АВАХ ХҮНСНИЙ МАТЕРИАЛЫГ БӨӨНИЙ ҮНЭЭР БУС ЖИЖИГЛЭНГИЙН ҮНЭЭР ХУДАЛДАН АВЧЭЭ.**

**1.1 Хоолны зардлын төсвийн төлөвлөлт, хуваарилалт оновч муутай, бодитой судалгаанд үндэслээгүй байна.**

**1.1.1 Эрүүл мэндийн байгууллагын хувьд хоолны зардалд үнийн тааз тогтоогоогүй, аймаг, сумдын хүн амын тооноос шалтгаалж ялгаатай төлөвлөсөн байна.**

1.1.1.1 ЭМТ-үүдийн төсвийн төлөвлөлтийн хувьд өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн, Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын 2015 оны 498/345 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг тооцох, хуваарилах аргачлал"-ын дагуу хийгддэг. Дээрх аргачлалд хоолны зардлын нормативыг нарийвчилж заагаагүй бөгөөд сумдын эрүүл мэндийн төв болон АНЭ-ийг хүн амын тоо, төв суурин газраас алслагдсан байдлыг харгалзан 1-4 ангилалд хувааж суурь зардалд үндэслэн хувьсах зардлыг тооцож олгож байна.

Хүснэгт №1

№	Эмнэлгийн нэр	Гүйцэтгэлийн тайлангаар /2019/	Хэвтэн эмчлүүлсэн хүний тоо	Нийт хүн ам	Нийт хүн амд харьцуулсан харьцаа /хонгогт/	Хэвтэн эмчлүүлэгчидэд харьцуулсан харьцаа
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	155,319,367	8074	21900	7092	19237
2	Онгон сум дундын эмнэлэг	12,008,949	676	3831	3135	17765
5	Асгат сумын ЭМТ	5,263,951	246	1889	2787	21398
6	Баяндалгар сумын ЭМТ	9,979,250	435	5046	1978	22941
7	Дарьганга сумын ЭМТ	6,356,905	387	3089	2058	16426
8	Мөнххаан сумын ЭМТ	14,540,696	447	4855	2995	32530
9	Наран сумын ЭМТ	4,986,075	149	1639	3042	33464
10	Сүхбаатар сумын ЭМТ	10,743,947	443	3347	3210	24253
11	Түвшинширээ сумын ЭМТ	11,800,000	253	3390	3481	46640
12	Түмэнцогт сумын ЭМТ	5,276,516	296	2483	2125	17826
13	Уулбаян сумын ЭМТ	6,075,313	273	2929	2074	22254
14	Халван сумын ЭМТ	4,581,200	215	1756	2609	21308
15	Эрдэнэцагаан сумын ЭМТ	7,596,291	367	6770	1122	20698

1.1.1.2 Дээрх хүснэгтээс харахад Түвшинширээ сумын ЭМТ нэг хэвтэн эмчлүүлэгчид 46.6 мянган төгрөг зарцуулсан байхад Түмэнцогт сумын эмнэлэг 17.8 мянган төгрөг зарцуулсан нь хоолны зардал харилцан адилгүй бодит судалгаанд үндэслэж хийгддэггүй байна.

1.1.1.3 Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “Нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасан боловч 2016 оны 242 тоот ЗГ-ын тогтоолоос хойш 2020 онд буюу 2020-2021 оны хичээлийн жилээс мөрдөгдөхөөр ЗГ-ын тогтоол гаргасан. Уг тогтоолд цэцэрлэг, дотуур байр, үдийн хоолны нэг хүүхдэд ногдох зардлыг 50% нэмж олгохоор тогтоожээ. Хүүхдийн тоонд үндэслэн хоолны зардлыг төлөвлөж байгаа боловч аймгийн төрийн сангийн мэргэжилтэн сум бүрд харилцан адилгүй хуваарилалт хийсэн байна.

**1.1.2 Хоолны зардлын төсвийг бодитой тооцоо судалгаанд үндэслэн хуваарилахгүй байна.**

1.1.2.1 Аймгийн ИТХ-аас тусгай шилжүүлгийн байгууллагын батлагдсан төсвийг хүүхдийн тоо, үйл ажиллагааны чиг үүрэгтэй уялдуулан хуваарилахгүй байна. Тухайлбал Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 8 дугаар зүйлийн 8.7-д заасны дагуу тухайн шатны

жилийн төсвийг сар улирлаар хуваарилан баталж, хэрэгжилтийг зохион байгуулахаар хуульд заасан боловч төсвийн мэргэжилтэн төсвийн хуваарийг ТЭЗ-аар хянаж, баталгаажуулаагүй, багц дотор өөрчлөх, хүүхдийн тоо, үйл ажиллагааны чиг үүрэгтэй нь холбоотой зарим байгууллагын төсвийг өсгөх, бууруулах зэргээр харилцан адилгүй төсөв батлагдсан байна. Хүүхдийн хоолны тооцоог өмнөх хичээлийн жилийн хүлээн авсан хүүхдийн тоонд үндэслэн төлөвлөж байгаа боловч зарим байгууллагын зардлыг үндэслэлгүйгээр бууруулж санхүүжүүлж байгаа нь нэг хүүхдэд ногдох хоолны мөнгө дутагдаж өр үүсэх, хоногт авах илчлэгийн хэмжээ буурах зэрэг сөрөг үр дагавартай байна.

**1.2 Хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан боловч хувь хүнээс хямдруулсан үнээр худалдан авах боломжтой хүнсний бүтээгдэхүүнийг жижиглэнгийн үнээр авч байна.**

**1.2.1 Мах, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүнээс бусад хүнсний материалын худалдан авалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан байна.**

1.2.1.1 Сумдад ЕБС, ЭМТ, хүүхдийн цэцэрлэгийн хоол хүнсний материалын худалдан авалтыг ЗДТГ-аас ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.1.1, Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалт явуулж, шаардлагад нийцсэн аймгийн болон орон нутгийн аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, худалдан авалт хийж байна.

1.2.1.2 Баруун-Урт сумын ЕБС, АНЭ, нэгдсэн дотуур байр, хүүхдийн цэцэрлэг хүнсний бөөний худалдаа эрхэлдэг (Өсөх дэлгэр ундрах ХХК, Номин супер маркет гэх мэт) аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж худалдан авалтыг хийдэг. Харин мах, сүү, сүүн бүтээгдэхүүнийг гарал үүслийн болон ариун цэвэр, эрүүл ахуйн шинжилгээнд хамрагдсан баримт материалд үндэслэн иргэн, хуулийн этгээдээс шууд худалдан авалт хийсэн байна. Сүүлийн жилүүдэд мал нядалгааны цэгүүд махыг өндөр үнээр авч байгаатай холбоотойгоор иргэдийн нийлүүлэлт хомсдож (үнэ хөлсийг цаг тухай бүр гаргаж өгдөггүй, татвар суутгадаг гэх мэт шалтгаанаас) махыг өндөр үнээр худалдан авч, төсөвт ачаалал үүсэж байгаа бөгөөд нэг хүүхдэд ногдох илчлэг ккал хангагдахгүй байх нөхцөл байдал үүссэн байна.

**1.2.2 Аймгийн төвийн байгууллагууд үхэр, хонины махыг сумдын дундаж үнээс 630-1051 төгрөгөөр өндөр үнээр бэлтгэж байна.**

1.2.2.1 Тус аудитад хамрагдсан төсвийн байгууллагууд 2019 онд хоолны зардалд 2,609.4 сая төгрөг зарцуулсан бөгөөд үүний 40 хувь буюу 1,044.9 сая төгрөгийг мах худалдан авахад зарцуулжээ. Үүнээс цэцэрлэгүүд 558.3 сая төгрөг, сургуулиуд 347.4 сая төгрөг, бусад байгууллага 141.2 сая төгрөгийг тус тус махны худалдан авалтад зарцуулжээ.

1.2.2.2. Хонины мах худалдан авсан жигнэсэн дундаж үнэд дүн шинжилгээ хийж үзэхэд сумдын дундаж үнэ 5516 төгрөг байна. Эрдэнэцагаан сумын дундаж үнэ сумдын дунджаас 685 төгрөгөөр бага, харин Сүхбаатар, Уулбаян сумын дундаж үнэ сумдын дунджаас 656-920 төгрөгөөр өндөр байна. Харин аймгийн төвийн байгууллагуудын дундаж үнэ 6567 төгрөг буюу сумын дунджаас 1051 төгрөгөөр өндөр, статистикийн хэлтсийн 7 хоног тутмын жижиглэнгийн үнийн дунджаас 1570 төгрөгөөр бага байна. Баруун-Урт сумын 1-р БДС, 3-р БДС болон 9-р цэцэрлэгүүд аймгийн төвийн дунджаас 537-1641 төгрөгөөр өндөр үнэтэй хонины мах бэлтгэсэн байна. Аймгийн төвийн байгууллагууд сумдын дундаж үнээр хонины мах бэлтгэсэн тохиолдолд 2019 онд нийт 12.6 сая төгрөгийн хэмнэлт гарах боломжтой байжээ.

1.2.2.3. Үхрийн мах худалдан авсан жигнэсэн дундаж үнэд дүн шинжилгээ хийж үзэхэд сумдын дундаж үнэ 6626 төгрөг байна. Халзан, Асгат сумд 5875-6013 төгрөг буюу сумдын дунджаас 612-751 төгрөгөөр бага, харин Сүхбаатар, Баяндэлгэр сум 7015-7065 төгрөг буюу сумдын дунджаас 389-439 төгрөгөөр өндөр үнэтэй байна. Аймгийн төвийн байгууллагуудын худалдан авсан үхрийн махны дундаж үнэ 7256 төгрөг буюу сумдын дунджаас 630 төгрөгөөр өндөр, статистикийн хэлтсийн 7 хоног тутмын жижиглэнгийн үнийн дунджаас 2273 төгрөгөөр

бага байна. Баруун-Урт сумын 2, 7, 9, 10-р цэцэрлэгүүд аймгийн төвийн дунджаас 310-623 төгрөгөөр өндөр үнэтэй мах бэлтгэсэн байна. Аймгийн төвийн байгууллагууд сумдын дундаж үнээр үхрийн мах бэлтгэсэн тохиолдолд 2019 онд нийт 33.5 сая төгрөгийн хэмнэлт гарах боломжтой байжээ.

1.2.2.4. Мах хүнсний ногооноос бусад хүнсний бүтээгдэхүүнийг албан ёсны гэрээ байгуулж тендер сонгон шалгаруулалтад шалгарсан супермаркет, бөөний төвөөс худалдан авалт хийж байгаа тул аймаг сумдын тусгай шилжүүлгийн болон ЭМТ, АНЭ зэрэг байгууллагууд ижил төрлийн бүтээгдэхүүн худалдан авахад үнийн зөрүү бага байдаг. Харин хувь хүнээс авч буй бүтээгдэхүүн мах, хүнсний ногоо, сүү сүүн бүтээгдэхүүний хувьд харилцан адилгүй, үнийн тогтсон жишиг байхгүй байна.

## **БҮЛЭГ 2. ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН НОРМ, НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ХАНГАХГҮЙ БАЙНА.**

**2.1 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд норм, нормативыг баримтлаагүй, хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын мэдээлэл тодорхой бус, ялгаатай хүснэгтүүдийг ашиглаж байна.**

### **2.1.1 Зарим ЭМТ-ийн нэг хүнд ногдох хоногийн хоолны зардал харилцан адилгүй байна.**

2.1.1.1 Сумдын эрүүл мэндийн төвийн хоолны зардал хүн амын тооноос хамаараад 1-4 ангиллын хооронд Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын дагуу харилцан адилгүй зарцуулагдаж байна. Тухайлбал: Асгат сумын ЭМТ нэг өвчтөнд өдөрт дунджаар 2968, Сүхбаатар сум 3291, Онгон сум 2379, Дарьганга сум 3418, Эрдэнэцагаан сум 2645, Наран сум 5300 төгрөг зарцуулж байна. Иймд хэвтэн эмчлүүлэгчдийн тоон болон өвчтөнд тохирсон хоолтой уялдуулан нэг өвчтөнд ногдох хоолны зардлын дээд хязгаарыг тогтоож өгөх шаардлагатай байна.

2.1.1.2 Сургуулиудын хувьд бага анги буюу үдийн цайнд хамрагдаж байгаа хүүхэд болон байрын хүүхдийн тоог үнэн зөв бүртгээгүйгээс төсвийг үр дүнгүй зарцуулсан байна. Асгат, Эрдэнэцагаан, Наран сумдын сургууль үдийн цайны зардлыг 3.8 сая төгрөгөөр илүү, Мөнххаан, Түмэнцогт сумдын сургууль байрын хүүхдийн хоолны зардлыг 8.2 сая төгрөгөөр илүү зарцуулж Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 дэх заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.

### **2.1.2 Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгтэд 13 төрлийн амин дэм, 14 төрлийн эрдэс бодисыг бүрэн тусгаж, олон нийтэд зориулж цахимд байршуулах шаардлагатай байна.**

2.1.2.1 Хоол зүйч, тогооч нарын хэрэглэж байгаа хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгтийг авч үзэхэд харилцан адилгүй байгаа бөгөөд хүнсний бүтээгдэхүүн нэр төрөл, тоон утга нь зөрүүтэй, амин дэм, эрдэс бодисын нэр төрөл ялгаатай байгаа нь тооцоолол хийхэд хүндрэлтэй байсан. Тодруулбал өөр хоорондоо ялгаатай 3 төрлийн<sup>1</sup> "Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгт" байна. ЭМС-ийн 2017 оны А/74 дүгээр тушаалаар 13 төрлийн амин дэм, 14 төрлийн эрдэс бодисыг зөвлөмж болгосон байхад "Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгт"-д хамгийн ихдээ 7 амин дэм, 9 эрдэс бодисын мэдээллийг тусгажээ. Түүнчлэн хонины махны илчлэгийг 100.3 ккал, 209.0 ккал, 305.2 ккал, үхрийн махны илчлэгийг 100.8 ккал, 177.9 ккал, 218.0 ккал зэргээр ялгаатай тусгасан байна. Мөн нягтлан бодогч, нярвууд хүнсний бүтээгдэхүүнийг материалын

1. <sup>1</sup>Уламжлалт болон өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний шимт бодисын найрлагын эмхэтгэл  
2. Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгт /100 гр бүтээгдэхүүн/  
3. Хүнсний 100 гр бүтээгдэхүүний химийн найрлага /Эрүүл зохистой хооллосноор халдварт бус өвчнөөс сэргийлэх нь ном УБ 2011 он М.Оюунбилэг, Ж.Батжаргал/

тайланд орлого авахдаа нэг ижил төрлийн бүтээгдэхүүний хэмжих нэгжийг ялгаатай бүртгэж байна. Тухайлбал гурилыг килограмм болон шуудайгаар, сүүг ширхэг болон литрээр, ургамлын тос, будааг килограмм болон ширхгээр орлого авсан байна. Иймд Сүхбаатар сумын ЭМТ-ийг сонгон авч, тус байгууллагын 2019 онд 3380 хүн/хоногт зарцуулсан 22 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний илчлэг, үндсэн шимт бодис, аминдэм, эрдэс бодисын хэмжээг тооцоолж, үр дүнг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт №2

Үзүүлэлт	Жишсэн дундаж хүнийн зөвлөмж хэмжээ	Хүн/хоног	Зөвлөмж хэмжээгээр тооцсон дүн	Хүнсний материалын зарцуулалтаас тооцсон дүн	Илүү, дутуу /д-г/	Илүү, дутуу /зөвлөмж хэмжээнд эзлэх хувиар/
а	б	в	г	д	е	ё
<b>Илчлэг, үндсэн шимт бодис</b>						
Илчлэг (ккал)	2,400.00	3380	8,112,000.00	7,009,452.60	-1,102,547.40	-13.6
Уураг, (г)	90	3380	304,200.00	282,149.57	-22,050.43	-7.2
Тос, (г)	67	3380	226,460.00	331,836.60	105,376.60	46.5
Нүүрс Ус, (г)	360	3380	1,216,800.00	749,142.37	-467,657.63	-38.4
Эслэг, (г)	30	3380	101,400.00	15,813.78	-85,586.22	-84.4
<b>Аминдэмүүд</b>						
А (мг)	0.6	3380	2,028.00	1,990.01	-37.99	-1.9
Е (мг)	0.01	3380	33.8	1,901.60	1,867.80	5,526.00
С (мг)	45	3380	152,100.00	157,663.48	5,563.48	3.7
<b>Эрдэс бодис</b>						
Кальци (мг)	1,000.00	3380	3,380,000.00	1,153,917.24	-2,226,082.76	-65.9
Төмөр (мг)	11.4	3380	38,532.00	33,222.58	-5,309.42	-13.8
Кали (мг)	4,700.00	3380	15,886,000.00	9,031,313.20	-6,854,686.80	-43.1
Натри (мг)	1,500.00	3380	5,070,000.00	4,224,438.44	-845,561.56	-16.7

2.1.2.2 Сүхбаатар сумын ЭМТ-ийн хувьд ЭМС-ын 2018 оны А/16-р тушаалаар батлагдсан "Хоол эмчилгээний удирдамж"-ийн дагуу өвчтөн тус бүрийн онцлогт тохирсон хоол хийж өгдөггүй боловч хэвтэн эмчлүүлэгч нартаа өөх тос, давс багатай хоол өгөхөд анхаарч ажилладаг байна. Иймд "Жишсэн дундаж хүний хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, шимт бодис, амин дэм болон эрдэс бодисын зөвлөмж хэмжээ"-г дээрх тооцоололд шалгуур үзүүлэлт болгож авсан. Дээрх хүснэгтээс харахад нүүр ус, эслэг бага байгаа нь гурил, гурилан бүтээгдэхүүн харьцангуй бага өгснийг илтгэж байна. Мөн кальци, кали агуулсан хоол, хүнсийг эмчилгээний хоол хүнсэнд түлхүү хэрэглэх шаардлагатай байгааг харуулж байна. Е аминдэмийн зөвлөмж хэмжээ 3380 хүнд 33.8 мг байгаа нь хэт бага байна. Учир нь 2019 онд тус ЭМТ-ын дундаж ор хоног 10-13 байгаа бөгөөд Е аминдэм агуулсан хүнсний бүтээгдэхүүний зарцуулалтын хувьд хоногт дунджаар 975 гр сүү, 160 г сонгино, 77 гр шар будааг хоолонд хэрэглэжээ. Эдгээрт агуулагдах Е аминдэмийн нийт хэмжээ нь 1,901.6 мг байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Хоногийн хоол хүнсээр авбал зохих аминдэмийн зөвлөмж хэмжээ"-нд заасан нэг хүний хоногийн Е аминдэмийн хэрэгцээ болох 0.01 мг-аар тооцож гаргасан 33.8 мг Е аминдэмээс хол зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл ЭМС-ын тушаалаар батлагдсан аминдэмийн зөвлөмж хэмжээнд Е аминдэмийн хэмжээг алдаатай тусгасан байж болзошгүй тул Е аминдэм болон бусад аминдэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг нягталж үзэх талаар ЭМГ-т зөвлөмж хүргүүлжээ.



## **2.2 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагыг хангахгүй байна.**

### **2.2.1 Хоолны технологийн картын бүтэц, агуулга одоогийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.**

2.2.1.1 Төсөвт байгууллагуудад хэрэглэж байгаа хоолны технологийн картын загвар, бүтэц, агуулга нь зарим талаар учир дутагдалтай байна. Тодруулбал ЭМС-ийн 2017 оны А/74 дүгээр тушаалаар 13 төрлийн амин дэм, 14 төрлийн эрдэс бодисыг өдөр тутмын хоол хүнсэнд хэрэглэхийг зөвлөмж болгосон байна. Харин тогооч, хоол зүйч нар технологийн картад тухайн хоолны илчлэг, үндсэн шимт бодисын мэдээллийг оруулахад түлхүү анхаардаг боловч амин дэм, эрдэс бодисын мэдээллийг бүрэн тусгадаггүй байна. Тухайлбал зарим байгууллагын хувьд А, С гэсэн 2 аминдэм, кальци, төмөр гэсэн 2 эрдэс бодисыг технологийн картад тусгасан бөгөөд бусад байгууллагын хувьд амин дэм, эрдэс бодисын мэдээллийг технологийн картад тусгадаггүй байна.

2.2.1.2 Хоол үйлдвэрлэлийн шаардлага болон эрүүл ахуй, халдвар хамгаалалтай холбоотой бүртгэлүүдийг бүрэн бус хөтлөх, нөхөж бүртгэх нийтлэг зөрчил, дутагдал аудитын явцад илэрсэн. Иймд тогооч нар эдгээр бүртгэлүүдийг хөтлөхөд зориулж өдөр бүр 20-30 минутыг төлөвлөх буюу ажлын цагийн хуваарьтаа тусгаж, тогтмол бүртгэж, хэвших шаардлагатай байна.

### **2.2.2 Эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл шаардлага бүрэн хангагдаагүй байна.**

2.2.2.1 Сүхбаатар сумын ЕБС-ийн цайны газрын хоол үйлдвэрлэлийн өрөөний плита ховхорч унасан, цаашид нэмж унах эрсдэлтэй буюу скочоор тогтоосон, агааржуулалтын систем /вентилятор/ нь ажиллаж байх үедээ чанга дуу чимээтэй, хэвийн бус ажиллагаатай, Сүхбаатар сумын Цэцэрлэгийн хоол бэлтгэх өрөө болон хоол үйлдвэрлэх өрөөний зохион байгуулалт нь хоол үйлдвэрлэлийн технологийн шат дамжлагын нэг чигийн урсгалд нийцээгүй, Дарьганга сумын хүүхдийн цэцэрлэгийн гал тогоо агааржуулагч байхгүй, угаалтуурын өрөө гал тогоонд цуг байдаг. Түвшинширээ сумын сургуулийн хоол бэлтгэгч давхар цэвэрлэгээгээ хийж байгаа нь Эрүүл ахуйн тухай хуулийн 6.2, Хүнсний тухай хуулийн 10.1.2, Хүнсний эрүүл ахуйн ерөнхий зарчим MNS CAC/RCP 1:2003 Дотоод бүтээц, тоноглол 4.2.2, Нийтээр нь үйлчлэх хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал MNS CAC/RCP 39:2011 стандартын 4.3.7.1-4.3.7.5-дахь заалтууд зөрчигдөж байна.

2.2.2.2 Мөн хүүхдийн цэцэрлэгийн хүртээмж, хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор Баруун-Урт сумын 7 дугаар цэцэрлэг яслийн, 9 дүгээр цэцэрлэг сургуулийн хүүхдийн дотуур байрны, 10 дугаар цэцэрлэг аж ахуйн /үйлдвэр үйлчилгээний/, 11 дүгээр цэцэрлэг сувиллын /сүүлд худалдаа үйлчилгээний зориулалтаар ашиглагдаж байсан/, Эрдэнэцагаан сумын 1 дүгээр цэцэрлэг ахуйн үйлчилгээний зориулалтаар тус тус ашиглагдаж байсан барилгыг их засвар хийж цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа боловч зарим цэцэрлэгийн гал тогооны заал хоол үйлдвэрлэлийн талбайн хэмжээ хүрэлцээгүй, агааржуулах систем хангалтгүй байна. Баяндэлгэр, Дарьганга, Наран, Халзан сумын цэцэрлэг нь цэцэрлэгийн зориулалтаар баригдсан хэдийн ч гал тогоо стандартын шаардлага хангахгүй байгаа талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан байна.

### **2.2.3 Тусгай шилжүүлгийн зарим байгууллагын хувьд тогоочийн орон тоо хүрэлцээгүй, илүү цагийн хөлс олгоогүй байна.**

2.2.3.1 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/024/11 тоот тушаалын хавсралтын 2.7 дах заалтад Сургууль нь үдийн цайны хөтөлбөрөө өөрөө зохион байгуулдаг бол тухайн гал тогоонд дотуур байрны тогооч хамаарахгүйгээр 1 тогооч нэмж ажиллуулж болно. Мөн сурагчдын дотуур байртай сургууль бага ангийн сурагчдын үдийн цай, үдийн хоолыг дотуур байрны гал тогооны хүчин чадлыг

нэмэгдүүлэх замаар бэлтгэж болно. Энэ тохиолдолд дотуур байрны тогооч, гал тогооны туслах ажилтныг нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативаар тооцсон цалин санд багтаан ажиллуулна гэж заасан байна. Дээрх заалттай уялдуулан Сүхбаатар, Түвшинширээ сумдын сургуулийн тогооч, гал тогооны туслах ажилтны орон тоог нэмэх зайлшгүй шаардлагатай бөгөөд цалин сан хүрэхгүй тохиолдолд илүү цагийн хөлсийг олгох нь зүйтэй байна. Бусад тусгай шилжүүлгийн байгууллагын хувьд тогоочийн орон тоо хэвийн байна.

**Холбогдох байгууллагын санал:**


**СҮХБААТАР АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас, факс: 70518302

2020.12.16 № 619  
танай 2020.12.08 -ны № 403 -Т

**АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ**

Төсвийн байгууллагуудын хоол, хүнсний зардлын зарцуулалт, үр ашигт байдалд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд оруулах санал байхгүй болно.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА  П.БОЛОРМАА

C/ My doc mayagt jijig blank  
**050797**

### **Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:**

Сүхбаатар аймгийн ЭМГ-ын 2020 оны 12 сарын 16-ны өдрийн 619 дугаар албан бичгээр санал байхгүй гэсэн хариу ирүүлсэн.

### **ДҮГНЭЛТ:**

1. Эрүүл мэндийн байгууллагын хувьд хоолны зардал харилцан адилгүй хуваарилагдсан, тусгай шилжүүлгийн байгууллагын хувьд нэг хүүхдэд ноогдох зардал бага байна.
2. Аймгийн төвийн байгууллагууд үхэр, хонины махыг сумдын дундаж үнээс 630-1051 төгрөгөөр өндөр үнээр, харин статистикийн хэлтсийн 7 хоног тутмын жижиглэнгийн үнийн дунджаас 1570-2273 төгрөгөөр бага үнээр бэлтгэж байна.
3. ЭМЯ-наас зөвлөмж болгосон 13 төрлийн амин дэм болон 14 төрлийн эрдэс бодисын 40 хувь нь хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын эмхэтгэлд ороогүй, 85 хувь нь хоолны технологийн картад тусгагдахгүй байна.
4. Эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл шаардлага бүрэн хангагдаагүй, хоол үйлдвэрлэлийн шаардлага болон эрүүл ахуй, халдвар хамгаалалтай холбоотой бүртгэл хөтлөлт хангалтгүй байна.

### **ЗӨВЛӨМЖ:**

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

1. ЭМГ-ын хоол тэжээл хариуцсан мэргэжилтэнд: ЭМС-ын тушаалаар батлагдсан амин дэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээг бодит байдалтай нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, мөн НЭМҮТ-өөс эмхэтгэсэн "Хүнсний бүтээгдэхүүний химийн найрлагын хүснэгт" дэх аминдэм, эрдэс бодисыг технологийн картад дэлгэрэнгүй тусгах зөвлөмжийг тогооч, хоол зүйч нарт өгч, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах.
2. Тогооч нарт: Хоол үйлдвэрлэлийн шаардлагатай холбоотой болон эрүүл ахуй, халдвар хамгаалалтай холбоотой бүртгэлүүдийг хөтлөхөд зориулж өдөр бүр 20-30 минутыг төлөвлөх буюу ажлын цагийн хуваарьтаа тусгаж, тэдгээр бүртгэлийг тогтмол бүртгэж, хэвших.
3. Нярав, нягтлан бодогч нарт: Хүнсний бүтээгдэхүүнийг материалын тайланд орлого авахдаа нэг төрлийн бүтээгдэхүүний ижил нэгжээр буюу аль болох грамм, килограммаар бүртгэж байх.
4. Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт: Тогоочийн орон тоо дутагдалтай байгаа сургууль, цэцэрлэг хамтарсан тушаалыг үндэслэн цалин санд багтаан орон тоог нэмэх шаардлагатай байна.



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 16 өдөр

Дугаар А/34

Баруун-Урт сум

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 тоот тушаал, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төсвийн байгууллагуудын хоол хүнсний зардлын зарцуулалт, үр ашиг" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2021 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Б.Гантулга/-д даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2020/tushaal